



100 ханог тутмын хэвлэл  
онч 08 дугаар сарын 04  
№29 /698/

ГЭМЭЛЭЛ

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

1310

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

1323

Дээд боловсролын  
санхүүжилт, суралцагчдын  
нийгмийн баталгааны тухай

НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс  
гаргасан зөвлөмжүүдийг  
2011-2014 онд хэрэгжүүлэх арга  
хэмжээний ерөнхий төлөвлөгөө  
батлах тухай



## ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |      |
|------|---|------|
| 322. | Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн шийгэмийн баталгааны тухай                              | 1310 |
| 323. | Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгох тухай                                   | 1321 |
| 324. | Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 1322 |
| 325. | Дээд боловсролын тухай хуулийн зарим бүлгийг хүчингүй болгох тухай                                | 1322 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |                            |           |      |
|------|----------------------------|-----------|------|
| 326. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 40 | 1322 |
|------|----------------------------|-----------|------|

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |            |      |
|------|---|------------|------|
| 327. | НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө батлах тухай | Дугаар 159 | 1323 |
| 328. | Төлөвлөгөө батлах тухай   | Дугаар 163 | 1333 |
| 329. | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай   | Дугаар 165 | 1339 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчдын нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль тогтоомж

2.1.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль тогтоомж нь энэ хууль болон энэ хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."дээд боловсролын сургалтын байгууллага" гэж Боловсролын тухай хуулийн<sup>1</sup> 15.1-д заасан байгууллагыг;

3.1.2."суралцагч" гэж Дээд боловсролын тухай хуулийн<sup>2</sup> 15.1-д заасан этгээдийг;

3.1.3."сургалтын төлбөр" гэж Боловсролын тухай хуулийн

<sup>1</sup> Боловсролын тухай хууль – Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 19 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Дээд боловсролын тухай хууль – Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



34.1, 36.11.4-т заасны дагуу Удирдах зөвлөлөөс тогтоосон суралцагчийн төлөх төлбөрийн хэмжээг;

3.1.4."суралцагчийн тэтгэлэг" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламжийг;

3.1.5."сургалтын зээл" гэж Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу элсэн суралцаж байгаа иргэний сургалтын төлбөр болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох зээлийг;

3.1.6."санхүүгийн дэмжлэг" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид буцалтгүй мөнгөн тусламж болон хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгийг.

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧИД ҮЗҮҮЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ**

**4 дүгээр зүйл. Дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах зарчим**

4.1. Дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1. дээд боловсролыг санхүүжүүлэхэд төр, суралцагч, ажил олгогч, дээд боловсролын сургалтын байгууллага тус тус хууль тогтоомжид заасны дагуу оролцох;

4.1.2. дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь сургалтын чанар, шударга өрсөлдөөнийг дэмжиж байх;

4.1.3. санхүүгийн дэмжлэг нь суралцагчийн амжилттай сурах, эзэмшсэн мэдлэг, чадвараа үр дүнтэй ашиглах боломж, чадварт нийцэж байх;

4.1.4. дээд боловсролын сургалтын байгууллага болон суралцагчид зориулсан зээлийн нөхцөл нь хөнгөлөлттэй, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн байх.

4.2.Дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангахад дараах үйл ажиллагааг хориглоно:

4.2.1.дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа нь нээлттэй биш, хөрөнгө орлого, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй байх, согтууруулах ундаа, мансууруулах бодис, хүн, байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс хандив, тусламж авах, тэдний үйл ажиллагааг сурталчлах, дэмжих, хувьцааг нь худалдан авах;

4.2.2.дээд боловсролын сургалтын байгууллага нь улс төр, шашны байгууллагаас тусламж, хандив авах, улс төрийн намыг хөрөнгө, үйл ажиллагаагаар дэмжиж ажиллах;

4.2.3.суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, түүнийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох агуулгатай сонгуулийн амлалт өгөх.

## **5 дугаар зүйл.Дээд боловсролын санхүүжилт**

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1.үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

5.1.2.улсын төсвийн хөрөнгө;

5.1.3.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтэд зориулсан хөрөнгө;

5.1.4.сургалтын төлбөр;

5.1.5.гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуйн бусад үйл ажиллагаанаас олсон орлого;

5.1.6.аж ахуйн нэгжээс эдийн засгийн сонирхолгүйгээр шилжүүлсэн хөрөнгийг эргэлтэд оруулснаас олсон орлого;

5.1.7.аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж, бэлэг;

5.1.8.зээлийн хөрөнгө;

5.1.9.бусад эх үүсвэр.



5.2 Дээд боловсролын сургалтын байгууллага нь бүх орлогоо санхүүгийн нэгдсэн тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглана.

5.3 Дээд боловсролыг санхүүжүүлэхэд зориулан улсын төсвөөс бүрдүүлэх хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Сургалтын төрийн санд төвлөрүүлэн дараах зориулалтаар зарцуулна:

5.3.1. төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, Боловсролын тухай хуулийн 43.1.4-т заасан зардлыг санхүүжүүлэх;

5.3.2. Засгийн газраас тодорхойлсон чиглэл, шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулсан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

5.3.3. улсын төсвөөс хуваарилсан хэмжээгээр Засгийн газраас тогтоосон журмын дагуу суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг санхүүжүүлэх;

5.3.4. дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэшлийг дэвшилүүлэх, давтан сургах зардлыг санхүүжүүлэх.

5.4 Дээд боловсролын сургалтын байгууллагад энэ хуулийн 5.3.1, 5.3.2-т заасан зориулалтаар улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн нийлбэр хэмжээ нь дээд боловсролын салбарын нийт орлогын 20 хувиас багагүй байна.

5.5 Дээд боловсролын сургалтын байгууллагыг үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зориулалтын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх үүргийг үүсэн байгуулагч хариуцна.

5.6. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

5.7. Энэ хуулийн 5.3, 5.4-т заасны дагуу санхүүжилт, санхүүгийн дэмжлэг авсан дээд боловсролын сургалтын байгууллага жил бүр аудитын байгууллагаар аудит хийлгэж, улсын төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн тайланг олон нийтэд ил тод мэдээлнэ.

5.8. Энэ хуулийн 5.3.2-т заасан нөхцөлөөр санхүүжүүлэх дээд боловсролын сургалтын байгууллагыг сонгон шалгаруулахад дараах шаардлагыг хэрхэн хангаж байгааг харгалзана:

5.8.1.улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах бүтэц, хариуцлагын тогтолцоо бүрдүүлсэн, үйл ажиллагааныхаа чанарын төвшинд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж баталгаажуулсан байх;

5.8.2.төгсгөгчдийнх нь ажил эрхлэлт нэмэгдсэн байх;

5.8.3.суралцагчдын сурлагын үнэлгээний бодитой байдал, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангасан байх;

5.8.4.суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдээлэл хүргэх, сурталчлах үйл ажиллагаа нь тогтворжсон байх;

5.8.5.удирдлагын мэдээлэл, бүртгэлийн тогтолцоо бүрдсэн байх;

5.8.6.сургуулийнхаа суралцагчид суралцагчийн тэтгэлэг, тусламж олгож хэвшсэн, үүнд шаардагдах хөрөнгийн тогтсон эх үүсвэртэй байх;

5.8.7.сургалтын төлбөрөө төлөх талаар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй суралцагчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо хэвшсэн байх;

5.8.8.дээд боловсролын үйлчилгээний чанарыг сургалтын бусад байгууллагатай харилцан хүлээн зөвшөөрч багц цагийг дүйцүүлэх, шилжүүлэх, харилцан тооцох зохицуулалтыг бий болгон мөрдөж хэвшсэн байх;

5.8.9.сургалтын төлбөр төлөх нөхцөлийг уян хатан байлгах боломж бүрдүүлсэн байх.

5.9.Дээд боловсролын сургалтын байгууллага нь эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, нийгмийн баталгаатай холбогдох мэдээллийн цахим сантай байх бөгөөд түүний мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

**6 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилго**

6.1.Энэ хууль нь Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад 5срлэх гадаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа болон суралцаж төгссөн Монгол Улсын иргэн, түүнчлэн гадаад

улсаас Монгол Улсад суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах, дээд боловсролын сургалтын байгууллагыг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, дэмжих, энэ ажлыг эрхлэх, зохицуулах, сурталчлах чиг үүрэг бүхий байгууллага, иргэнээс суралцагчид үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны нийтлэг зарчим, хэм хэмжээг тодорхойлно.

6.2.Төрөөс суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангахад дараах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

6.2.1.суралцагчид чанартай боловсрол, мэргэжил эзэмшихэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн дэмжлэг, урамшуулал, нийгмийн үйлчилгээний олон төрлийн эх үүсвэрийг бий болгох;

6.2.2.дээд боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх.

### **7 дугаар зүйл.Төрөөс санхүүгийн дэмжлэг авах суралцагчид тавих нийтлэг шаардлага**

7.1.Санхүүгийн дэмжлэгийг энэ хуульд заасан шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа дараах шаардлагын аль нэгийг хангасан суралцагчид олгоно:

7.1.1.дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч элсүүлэх шаардлагыг бүрэн хангаж, суралцах чадвар, идэвх санаачилга, төлөвшлөө илтгэн харуулсан;

7.1.2.тодорхой мэргэжлийн чиглэлээр суралцаж, тогтоосон газар нутагт ажиллах гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн;

7.1.3.сургалтын зээл олгох нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн.

7.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад хамрагдсан гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад хувийн зардлаар амжилттай суралцан төгсгөж эх орондоо ирж тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэнд суралцах хугацаандаа гаргасан зардлын тодорхой хувийг төрөөс буцаан олгож болно.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан иргэнд суралцах хугацаандаа гаргасан зардлын тодорхой хэсгийг буцаан олгох журмыг Засгийн газар батална.



7.4. Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах гадаадын иргэнд суралцагчийн тэтгэлэг, тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл, журмыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Засгийн газар тогтооно.

### **8 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэлбэр**

8.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

8.2. Боловсролын тухай хуулийн 28.1.8-д заасны дагуу аттестатчилагдсан дээд боловсролын сургалтын байгууллагад, энэ хуулийн 7.1.1-д заасан шаардлагыг ханган өдрийн ангид суралцаж байгаа суралцагчид суралцах хугацаанд нь сар бүр үндэсний тэтгэлэг олгоно. Хичээлийн нэг жилд олгох үндэсний тэтгэлгийн доод хэмжээ нь 10 сарын турш сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байна.

8.3. Суралцагчид улсын төсвөөс олгох суралцагчийн тэтгэлэг нь үндэсний тэтгэлэг, нэрэмжит тэтгэлэг гэсэн хэлбэртэй байна.

8.4. Сурлагын өндөр амжилт гарган суралцаж байгаа суралцагчид, түүнчлэн тодорхой шалгуур хангасан дээд боловсролын сургалтын байгууллагад болон Засгийн газраас тодорхойлсон эрэлт ихтэй мэргэжлээр суралцагчид урамшууллын тэтгэлэг олгоно.

8.5. Орон нутгийн мэргэжилтэй ажилтны хэрэгцээг хангах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид зориулсан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд уг дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

8.6. Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэн болон сургалтын байгууллага тодорхой нөхцөл, болзол хангасан суралцагчид өөрийн нэрэмжит тэтгэлэг олгож болох бөгөөд уг тэтгэлгийн болзол, нөхцөлийг тэтгэлэг олгогч этгээд тогтооно.

8.7. Гаднаад улсад дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа Монгол Улсын иргэнд Засгийн газраас тогтоосон журмын дагуу



суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгож болно.

8.8.Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

8.9.Суралцагчид олгох сургалтын зээлийн нийт хэмжээ нь суралцагчийн суралцах хугацааны сургалтын төлбөр, амьжиргааны зардлын нийлбэрээс хэтрэхгүй байх бөгөөд сургалтын зээлийг буцаан төлүүлэхдээ зээлдэгчийн амьжиргаанд нь дарамт үүсгэхгүйгээр суутгал хийхээр журамлана.

8.10.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид улсын төсвөөс олгох сургалтын зээл нь хөнгөлөлттэй, эргэн төлөгдөнө.

### **9 дүгээр зүйл.Суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлын зохион байгуулалт**

9.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байна.

9.2.Дээд боловсролыг санхүүжүүлэх, суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн төлөвлөлт, хуваарилалтыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

9.3.Суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх байгууллага нь Сургалтын төрийн сан байх бөгөөд суралцагчид төрөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг чанартай боловсролд сонгон хэрэглэх боломж нь нээлттэй байна.

9.4.Төрөөс санхүүгийн дэмжлэг авсан суралцагчдын бүртгэл, мэдээллийн сангийн үйл ажиллагааг Сургалтын төрийн сан эрхэлнэ.

9.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн тэтгэлэг, суралцагчид улсын төсвөөс болон бусад эх үүсвэрээс олгох санхүүгийн боломжит туслалцаа, хөдөлмөр эрхлэх асуудлаар мэдээлэл түгээх, сургалтын зээлийн гэрээ байгуулахад шаардагдах зөвлөгөө, лавлагаа өгөх зэрэг үйлчилгээ үзүүлж, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлнэ.



## **ГУРАВДУГААР БҮЛЭГ СУРАЛЦАГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ**

**10 дугаар зүйл. Суралцагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт**

10.1 Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийг дадлага хийх, цагийн хөдөлмөр эрхлэх боломж бүрдүүлэх, хичээлийн байр, номын сан, нийтийн хоол, биеийн тамир, спортын танхимаар үйлчлүүлэх нөхцөлөөр хангана.

10.2 Суралцагчид мэдээлэл, нийгэм, соёл, эрүүл мэнд, биеийн тамирын үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр үйлчлэхийг дэмжих нэгдсэн бодлогыг Засгийн газар боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангана.

10.3 Дээд боловсролын сургалтын байгууллагын өдрийн ангид суралцагчийн эрүүл мэндийн даатгалыг төр хариуцна.

10.4 Байнгын ажил эрхэлж байгаа суралцагчид шалгалт, шүүлгийн үеэр болон төгсөлтийн шалгалт өгөх, дипломын ажил бичиж хамгаалахад зориулж ажил олгогч нь цалинтай чөлөө олгоно.

10.5 Гадаад улсаас Монгол Улсад ирж суралцагчид дэмжлэг, тусламж үзүүлэх нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, мэдээллээр хангах, тайлагнах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

10.6 Гадаад улсад суралцаж байгаа Монгол Улсын иргэний бүртгэлийг хөтөлж, түүнд холбогдох мэдээллээр үйлчлэх, шаардлагатай тусламж, дэмжлэг үзүүлэх үүргийг тухайн оронд суугаа, эсхүл тухайн орныг хамаарагч Монгол Улсын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар хариуцна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨРӨӨС СУРАЛЦАГЧИД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

**11 дүгээр зүйл. Дээд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг**

11.1 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйл, тусгай зөвшөөрөл эрхээс гадна дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид

санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааг төрийн бодлогын хүрээнд уялдуулан зохицуулж дэмжих, тэднийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

11.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй санхүүгийн дэмжлэг олгох, суралцагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллана.

## **12 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг**

12.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчдаа санхүүгийн дэмжлэгт хамруулах, өөрийн нэрэмжит тэтгэлэг олгох, санхүүгийн эх үүсвэр, хуримтлал бүрдүүлэх, түүнийг ашиглах талаар бодлого, стратеги, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх бүрэн эрхийг эдэлнэ.

12.2. Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.2.1. суралцагч нь санхүүгийн дэмжлэг авах нөхцөл, болзол хангасан бол түүнийг олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах;

12.2.2. суралцагчид санхүүгийн дэмжлэг олгох ажлын үр дүнг санхүүжүүлэгч байгууллага, этгээдэд тайлагнах;

12.2.3. санхүүгийн дэмжлэг олгох нөхцөл, болзолын талаар суралцагчид мэдээлэл, зөвлөгөө өгөх;

12.2.4. суралцагчийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан байдлын талаар тайлан мэдээ тогтмол гаргаж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

12.2.5. суралцагчид олгох санхүүгийн дэмжлэгийн талаар иргэдэд сурталчлах;

12.2.6. суралцагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орлого олох арга хэмжээг зохион байгуулж болно.

12.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.3.1. цагийн, түр хугацааны болон гэрээт ажлын байр, ажиллуулах нөхцөлийн тухай мэдээллээр хангах;

12.3.2.суралцагчийн цагийн, түр хугацааны болон гэрээт ажил, үйлчилгээний цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, ажлын орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын талаар мэдээлэх, сургалт, зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулж, хуульд заасан эрхээ эдлэхэд нь туслах;

12.3.3.суралцагчид цагийн болон гэрээт ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд анхаарах хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуй, ажлын байрны сахилга бат, ёс зүй, онцлогийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх;

12.3.4.суралцагчид суралцаж байх хугацаандаа ажлын байр олоход нь тусалцаа үзүүлж, ажил олгогчийн зүгээс тавьж байгаа нөхцөл, болзол, шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх;

12.3.5.суралцагчийг ажил олгогчидтой уулзуулах, ирээдүйн ажлын байртай нь танилцуулах, мэргэжлийн дадлага хийхэд нь тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.

### **13 дугаар зүйл.Санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагчийн эрх**

13.1.Санхүүгийн дэмжлэгт хамрагдах суралцагч дараах эрх эдэлнэ:

13.1.1.санхүүгийн дэмжлэг авах нөхцөл, болзол, шалгуур үзүүлэлтийн талаар холбогдох байгууллагаас мэдээлэл авах;

13.1.2.санхүүгийн дэмжлэг авах шаардлага хангасан бол хүсэлтээ гарган сонгон шалгаруулалтад оролцох;

13.1.3.санхүүгийн дэмжлэг үзүүлэх байгууллагыг сонгох, тэднээс татгалзах, гэрээ байгуулах, цуцлах зэрэг холбогдох асуудлаар мэдээлэл авах.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

#### **14 дүгээр зүйл.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

14.1.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараах хариуцлага ногдуулна:

14.1.1.энэ хуулийн 4.2.1, 4.2.3-т заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хууль бусаар элдэв орлогын хуримт буюу хураахгүйгээр иргэнийг 100000-250000 төгрөгөөр, хуулийн этгээдийг



500000-1000000 төгрөгөөр тус тус торгох;

14.1.2.энэ хуулийн 5.7-д заасан үүргээ биелүүлээгүй дээд боловсролын сургалтын байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр, буруутай албан тушаалтныг 250000-500000 хүртэл төгрөгөөр тус тус торгох;

14.1.3.энэ хуульд заасан санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, хандивын талаарх нягтлан бодох болон санхүүгийн бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй хуулийн этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

14.1.4.энэ хуулийн 12.2.3-т заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтныг 50000-150000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 150000-250000 төгрөгөөр торгох.

14.2.Суралцагчдын сургалтын төлбөр, сургалтын эзэл, суралцагчийн тэтгэлэг, нийгмийн баталгааны асуудлаар санаатайгаар хуурамч баримт, бичиг бүрдүүлсэн, сургалтын дүнг засч сургалтын эзэл, суралцагчийн тэтгэлэг авсан, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт эдэлсэн, холбогдох мэдээ тайлан, мэдээллийг удаа дараа буруу гарган ирүүлсэн нь эрүүлийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 100000-250000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгоно.

### 15 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

15.1.Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2011 оны 7 дугаар сарын 09-ний өдөр баталсан Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.10-т заасны дагуу дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр сургалтын зардлыг нь төрөөс хариуцаж байсан суралцагчдад тухайн сургуулиа төгсгөх хүртэл уг зардлыг үргэлжлүүлэн олгоно.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ БҮЛГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дээд боловсролын тухай хуулийн "Дээд боловсролын эдийн засаг, нийгмийн баталгаа" гэсэн Наймдугаар бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2010 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын цалин, тэтгэлэг, тэтгэмж, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 05 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар  
хот

### **НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө батлах тухай**

"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Эрхлэх ажлынхаа хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн 2014 онд биелэлтийг нь гаргахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн үндэсний комисст зөвлөсүгэй.

3. Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжилтэд нь ерөнхий хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Г.Занданшатарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**





Засгийн газрын 2011 оны 159 дүгээр  
тогтоолын хавсралт

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС  
ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2011-2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
1	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэмэлт II Протоколд нэгдэн орох	ГХЯ	2011
2	Иргэдийнхээ эрхийг бүрэн хамгаалах, хөхиүтэн дэмжих зорилгоор НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтран ажиллах, техникийн туслалцаа авах	ГХЯ	2011-2014
3	Ямар ч хүнийг хүчээр алга болгохоос хамгаалах тухай олон улсын Конвенцийг соёрхон батлуулах арга хэмжээ авах	ХЗДХЯ	2011-2013
4	Цагаар авах ялын тухай эвэлтэг үндэсний хууль тогтоомжоос хасуулах арга хэмжээ авах	ХЗДХЯ	2011-2012
5	Цагаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн талаархи мэдээллийг ар гэрийнхэнд нь өгөх зорилгоор төрийн нууцад хамааруулан 1990 оноос хойшхи хугацаанд оногдуулсан цагаар авах ялын тоо баримтыг нийтэд ил болгох	ХЗДХЯ, УАБЗ-ийн Ажлын алба	2011-2012
6	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцүү, хүнлэг бусаар буруу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцийн Нэмэлт Протоколыг соёрхон батлуулах арга хэмжээ авах	ХЗДХЯ	2011-2012



7	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенцид нийцүүлэн бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулж батлуулах	ХЗДХЯ	2011-2012
8	Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох хөтөлбөрийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын дунд хэрэгжүүлж, ийм хэрэг үйлдэгчид ял завшихаас сэргийлэх мөрдөн шалгах механизм бий болгох	ХЗДХЯ	2011-2014
9	Эрүүдэн шүүхийн эсрэг Тусгай илтгэлчээс өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2012
10	Хүний эрх зөрчих явдлыг хуулийн гадна үлдээхгүйн зорилгоор Эрүүгийн хуулийн 44.1-ийг хасах буюу өөрчлөх, мөн Эрүүгийн хуулийн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенцийн тодорхойлолтод нийцүүлэх арга хэмжээ авах	ХЗДХЯ	2011-2012
11	Үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг үр дүнтэй хэрэглэх зорилгоор шүүгчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2014



12	Гэрч, хохирогч, хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хамгаалах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэний оролцоог баталгаажуулах, хэвлэн нийтлэгчдийн хараат бус байдал, нийтийн эрх ашгийг хөндсөн хэрэг, маргаанд оролцох иргэдийн эрхийг хангах арга хэмжээ авах	ХЗДХЯ	2011-2014
13	Хүн худалдаалах далд гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, хүний наймааны эсрэг хууль гаргах, түүнчлэн түүнд хяналт тавих үндэсний хэмжээний механизм бий болгох	ХЗДХЯ	2011-2012
14	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг өргөн оролцуулах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2014
15	Гадаадын иргэдийн эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ханган хамгаалах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2014
16	Хүмүүсийг ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах асуудлаархи Тусгай илтгэгчтэй хамтран ажиллах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2012
17	Хүний эрхтэй байдлаар хэрэглэх тухай сургалтад цагдаагийн албан хаагчдыг эзэвэл хамруулах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2012
18	Хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа бүх хүмүүсийг хамгаалах тухай НҮБ-ын Зарчим, Хоригдлуудтай харьцах нээд захын жишгийн тухай НҮБ-ын стандартыг хэрэгжүүлэх замаар хорих байгууллагуудын нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажиллах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2014
19	Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенцид тусгагдсан хувь хүний гомдлыг хянан шийдвэрлэх механизмыг нэвтрүүлэх боломжийг судлах	ХЗДХЯ, УЕПГ, ХЗҮК	2011-2012



20	Эрүүгийн хуульд үзэн ядах гэмт хэргийн талаар тусгуулах, улмаар ийм гэмт хэргийн хошигногчдын эрхийг хамгаалах арга хэмжээ авах	ХЗДХЯ, УЕПГ	2011-2012
21	Хүүхдийн эрхийн Конвенцэд дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах, бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгахад чиглэсэн хууль тогтоомж батлуулах, 18 нас хүрээгүй хүүхдээр аюултай ажил хийлгэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэн Олон улсын Хөдөлмөрийн байгууллагаас туслацгаа авах боломжийг эрэлхийлэх	НХХЯ, ШСАА	2011-2012
22	Хүүхдийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний механизмыг бэхжүүлэхэд чиглэсэн үүрэг амлалтаа үргэлжлүүлэн биелүүлэх	НХХЯ, ШСАА	2011-2014
23	Ирэх 10 жилд хэрэгжүүлэх Хүүхдийн хөгжил, хамгааллыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр батлах	НХХЯ, ШСАА	2011-2012
24	"Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлчлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг бүрэн хэрэгжүүлэх	НХХЯ, ХЗДХЯ, ГХЯ, СЯ, ЭМЯ, БСШУЯ	2011-2014
25	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	НХХЯ	2011-2012
26	Ядуурлыг (ялангуяа хотын зах болон орон нутагт) арилгах стратегийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах	НХХЯ, УХШХ	2011-2014

27	Ядуурлыг арилгах, амьжиргалмыг бууруулах, нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалах асуудалд түлхүү аюулаарх	НХХЯ	2011-2014
28	Нийгмийн эмзэг бүлгийн, тэдгээрээс ялангуяа эмэгтэйнүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх	НХХЯ	2011-2014
29	Хугацаа хожимдуулсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаархи эзлэлт илтгэлийг нөхөн хүргүүлэх	НХХЯ	2011
30	Эмэгтэйнүүд, охидтой зүй бусаар харьцах, тэднийг алагчлахтай тэмцэх талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг ханган, үндэсний хууль тогтоомжийг олон улсын баримт бичгүүдэд нийцүүлэх чиглэлээр арга хэмжээ авах	НХХЯ, ХЗДХЯ	2011-2012
31	Эмэгтэйнүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах, тэгш хөдөлмөр эрхлэлтийг баталгаажуулах	НХХЯ	2011-2014
32	Ажлын гүйцэтгэлд нь тохирсон цалин хөлс өгөх явдлыг хангах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлыг судлан, холбогдох арга хэмжээ авах	НХХЯ	2011-2014
33	Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхэд, эмэгтэйнүүдийн эрхийг хамгаалах, дэмжих чиглэлээр ажиглах	НХХЯ	2011-2014
34	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад шаардлагатай арга хэмжээ авах, энэ чиглэлээр олон улсын хэмжээнд хамтран ажиглах	БОАЖЯ, УЕПГ	2011-2014

35	Хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын үр нөлөөг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлын талаар олон нийтэд мэдээлэл түгээх, энэ талаар мэдлэг олгох	БОАЖЯ, УЕПГ	2011-2014
36	Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй, ялангуяа эрүүл ахуйн тогтолцооны талаархи тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах	БОАЖЯ	2011-2014
37	Ерөнхий боловсролын хөтөлбөрийг аль болох анги танхимын сургалтаар олгох боломжийг нэмэгдүүлэх	БСШУЯ	2011-2014
38	Сургууль завсардах (ялангуяа хөвгүүд) явдлын эсрэг шаардлагатай арга хэмжээ авах	БСШУЯ	2011-2014
39	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах талаар идэвхтэй ажиллах	БСШУЯ	2011-2012
40	Эрүүдэн шүүсэн этгээдүүд ял завшихаас урьдчилан сэргийлэх	УЕПГ, ХЗДХЯ	2011-2014
41	Бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар алагчлахыг хатуу хориглосон хууль тогтоомж боловсруулан, хэрэгжилтийг хангах	НХХЯ, ХЗДХЯ, УЕПГ	2011-2014
42	Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг устгах талаар хүчэн чармайлт гаргах, ийм төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх, мөн хэргийн хохилогчдыг хамгаалах, нийгэмшүүлэх, нөхөн олговор олгоход анхаарах	ХЗДХЯ, НХХЯ, УЕПГ	2011-2014



43	Хүн худалдаалах гэмт хэргийн хохиролч болсон эмэгтэйчүүд, охидаг нийгэмшүүлэх үр нөлөөтэй механизмзыг бүрдүүлэх, Палермогийн Протоколын хэрэгжлтийг хангах зорилгыг харгалзан Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжийн дагуу "Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр"-ийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх, энэ чиглэлээрх олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ийм торлийн гэмт хэрэг үйлдэгчид ял зөвшөөх явдлаас сэргийлэх чиглэлийн хууль сахиулах болон шүүх тогтолцоог бэхжүүлэх	ХЗДХЯ, НХХЯ, УЕПГ	2011-2014
44	Авлигын гэмт хэргийг Төрийн нууцын тухай хуулийн хүрээнд хамааруулах асуудлыг хязгаарлаж, үйл ажиллагаа, шийдвэрийг ил тод болгох	ХЗДХЯ, АТГ, ҮАБЭЗ-ийн Ажлын алба	2011-2012
45	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролын сургалтын хөтөлбөрт хамруулах орчин нөхцөлийг аажмаар бүрдүүлэх	БСШУЯ	2011-2013
46	Эхчүүдийн нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх	ЭМЯ, НХХЯ	2011-2014
47	ХДХВ/ДОХ болон аливаа бусад байдлаар алэгчлэх явдлыг хориглох, устгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ийм хэрэг үйлдэгчдийг шийтгэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ЭМЯ, НХХЯ	2011-2014
48	Хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд хүчин чармайлт гаргах	ХХААХУЯ	2011-2014

49	Үндэсний боловсролын болон эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	БСШУЯ, ЭМЯ	2011-2014
50	Иргэдийн сурч боловсрох болон эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх	БСШУЯ, ЭМЯ	2011-2014
51	Хоол тэжээлийн хомсдол, сүрьеэ өвчний эсрэг арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх	ХХААХУЯ, ЭМЯ	2011-2014
52	Хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар "ЛИБТ" хүмүүсийг алагчлах үзлийг арилгах, тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах	НХХЯ, БСШУЯ, УБЕГ	2011-2014
53	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, тэдгээрийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг үргэлжлүүлэн бүрдүүлэх	НХХЯ, БСШУЯ, СЕХ	2011-2012
54	Нийт хүн ам, ялангуяа гэр хороололд оршин сууж байгаа хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх, боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, ундны усны аюулгүй байдлыг хангах, эрүүл ахуйг бүрдүүлэх, мөн орон сууцнуулах чиглэлээр хүчин чармайлт гаргах	ЭМЯ, БСШУЯ, БОАЖЯ, ЗТБХБЯ	2011-2014
55	Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүд болон Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах	Бүх яамд	2011-2014
56	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хөхиүлэн дэмжих, сэтгэл зүйн болон дэд бүтцийн орчинг бүрдүүлж, тэдгээр хүмүүсийн эрхийг хамгаалахад холбогдох бүх байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх	Бүх яамд	2011-2012



57	Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц хариуцсан байгууллагуудад холбогдох илтгэлийг цаг тухайд нь хүргүүлж байхад онцгой анхаарах	Бүх яамд	2011-2014
58	Шийдвэр гаргах дээд төвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар төрийн болон хувийн салбар дахь алагчлах явдалтай тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Бүх яамд	2011-2014
59	Омог, оттоор амьдардаг хүмүүст зохих хамгаалалт үзүүлэх	Бүх яамд	2011-2014
60	Цагдаагийн албан хаагчдын үйлдсэн хүчирхийллийн хэргийг хараат бусаар мөрдөн шалгах зорилгоор Улсын оронхий прокурорын газрын дэргэдэх мөрдөн байцаах албыг бэхжүүлэх	УЕПГ	2011-2012
61	Жендэрийн тэгш байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд "А" үнэлгэтэйгээр магадлан итгэмжлэгдсэн Хүний эрхийн үндэсний комиссын гүйцэтгэх Үүргийг нэмэгдүүлэх	ХЗҮК	2011-2014
62	Хүнийг итгэл үнэмшлээр нь эвлэлдэн нэгдэж, зохих бүртгэлд хамрагдах эрхийг үл алагчлах байдлаар хангах	УБЕГ	2011-2014

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 163

Улаанбаатар  
хот

**Төлөвлөгөө батлах  
тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Дундговь, Төв, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Булган, Хөвсгөл аймгуудад хэрэгжүүлэх зарим арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод, хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сайд нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

**ӨВӨРХАНГАЙ, БАЯНХОНГОР, АРХАНГАЙ, ДУНДГОВЬ,  
ТӨВ, ДОРНОД, СУХБААТАР, ХЭНТИЙ, БУЛГАН, ХӨВСГӨЛ  
АЙМГУУДАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа /оноор/	Хариуцах байгууллага
Нэг. Архангай аймаг			
1	"Шинэ хороолол" байгуулах ажлын хүрээнд 2012-2016 онд жил бүр 60 айлын орон сууц барихад шаардагдах дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний зардлын эх үүсвэрийг улсын төсөвт тусгах асуудлыг судалж шийдвэрлэх	2012-2016	ЗТБХБЯ
2	МУБИС-ийн харьяа Багшийн сургуулийн багш, ажилчдыг эзэлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012	БСШУЯ
3	Багшийн сургуулийн оюутны дотуур байрны асуудлыг судалж шийдвэрлэх	2012	БСШУЯ, СЯ
Хоёр. Хөвсгөл аймаг			
1	Гэмт хэргийн ул мөрийг бэхжүүлэх криминалистикийн автомашины худалдан авахад шаардагдах хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2012-2013	ХЗДХЯ, СЯ
2	Аймгийн онцгой байдлын хэлтэст усан дор ажлаах тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 250.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2013	ОБЕГ

3	Хатгал тосгоны өрөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2011-2012	ЗТБХБЯ
4	Хатгал тосгоныг шалтэн кабельд холбох хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2011-2013	МШХХТГ
5	Хатгал тосгоны соёлын төвийг шинээр барих хөрөнгийг 2012 оны төсвийн төсөлд тусгах асуудлыг судалж шийдвэрлэх	2012	БШУЯ, СЯ
6	Хатгал тосгоны дунд сургуулийн урлагийн заалыг зөвж барихад шаардагдах 12.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2012	БШУЯ
7	Хатгал тосгоны дунд сургуулийн биеийн тамирын заалыг шинээр барих буюу засварлах асуудлыг судалж шийдвэрлэх	2012	БШУЯ, СЯ
8	Хатгал тосгоны дунд сургуульд дижитал номын сан байгуулах асуудлыг шийдвэрлэх	2012	БШУЯ
Гурав. Сүхбаатар аймаг			
1	2.6 км үерийн суваг барих хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэх	2012	ЗТБХБЯ
Дөрөв. Өвөрхангай аймаг			
1	Жижиг, дунд үйлдвэрийн эзэлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, банкны барьцаатай холбоотой асуудлыг судалж шийдвэрлэх	2011	ХХААХҮЯ
2	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг топографийн тоног төхөөрөмжтэй болгох асуудлыг шийдвэрлэх	2012	ЭМЯ



3	Блзийт сумын хүн эмнэлгийн автомашиныг шинэчлэх, Хархорин сумын хүн эмнэлгийг эхө, рентгенний аппаратаар хангах асуудлыг шийдвэрлэх	2011-2012	ЭМЯ
4	Элсэнтасархайгаас Хархорин сум чиглэлийн автозамыг шинэчлэн засварлах ажлыг шийдвэрлэх	2012-2013	ЗТБХБЯ
5	2010 онд ажил нь эхэлсэн Хархорин сумын инженерийн цугам, сүлжээний ажлыг дуусгах арга хэмжээ авах	2011-2012	ЗТБХБЯ
6	Орхоны хөндийн соёлын дурсгалт газрууд болон Хархорин хотын орчмоос олдсон олдворуудыг Хархорин сумын музейд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012	БСШУЯ
Тав. Хэнтий аймаг			
1	Өндөрхаан-Норовлин-Ульхан-Дадатын чиглэлийн хөтүү хүчилтгай замын зураг төсөл хийх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх	2011-2012	ЗТБХБЯ
2	Их эзэн Богд Чингис хааны өлгий нутгийг аялал жуулчлалын томоохон төв болгож, цогцолбор байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх	2012-2015	БОАЖЯ
Зургаа. Дорнод аймаг			
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр барих хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012	ЗГХЭГ, СЯ



2	Чойбалсан хотоос хилийн Хавиргын боомт хүртэлх 140 км хатуу хучилттай замыг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймагтай хамтарсан хөрөнгө оруулалтаар барих ажлын хүрээнд Чойбалсан хотоос Чойбалсан сум хүртэлх 50 км хатуу хучилттай зам барихад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2012	ЗТБХБЯ
3	Хавирга, Баянхоншуу, Ульхан боомтоор нэвтрэх жуулчдад Хөлөнбуйр хотод виз олгох асуудлыг судлан шийдвэрлэх	2012-2013	ГХЯ
4	1.3 тэрбум төгрөгийн өртөгтэй 640 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг 2011 оны хичээлийн шинэ жил эхлэхээс өмнө дуусгах	2011	БСШУЯ, СЯ
5	Аймгийн төвд шөнөөр ашиглалтад орох хөгжимт, жүжгийн театрын тайзны гэрэлтүүлэг, дуу авианы тоноглол, үзэгчдийн сандал зэрэг тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 600.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2012	БСШУЯ
6	Адуунчулууны нүүрсний уурхайн ашиглалтын талбайн хил хязгаарыг тогтоох	2011 оны II улиралд	ЗБЭХЯ
7	Мянгань замын хөндлөн гол тэнхлэгт тавигдаж байгаа замыг Чойбалсан хотоос баруун тийш угуулан барих асуудлыг шийдвэрлэх	2011	ЗТБХБЯ
Долоо, Өмнөговь аймаг			
1.	Батмөнх Даян хааны нэрэмжит талбай байгуулахад шаардлагатай байгаа 250.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2012	БСШУЯ, СЯ



Найм. Баянхонгор аймаг

1	Номундалай цогцолбор сургуулийн хичээлийн байрны их зэвсэрт шаардагдах 150.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012	БСШУЯ
2	Соого-Сейко сургуулийн өргөтгөлийн барилгыг барьж 12 жилийн сургалттай сургууль болгоход шаардагдах 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2012	БСШУЯ
3	Баянхонгор хотод шинэ суурьшлын бүс бий болгох ерөнхий төлөвлөгөөний зураг, төсөл хийлгэх 85.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2011-2012	ЗТБХБЯ, СЯ

Ес. Булган аймаг

1	БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах 10 махны үйлдвэрийн нэгийг Булган аймгийн төвд барих асуудлыг судалж шийдвэрлэх	2012-2013	ХХААХУЯ
2	Аймгийн төвд өвс тэжээл, хүнсний нөөцийн газар байгуулах 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2012-2014	ОБЕГ
3	Хутаг-Өндөр суманд сургуулийн өргөтгөлийн барилга шинээр барихад шаардагдах 250.0 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2012	БСШУЯ

Арав. Төв аймаг

1	Төвийн бүсийн тулгуур төв-Зуунмод хотын дулааны станцад техник, технологийн шинэчлэл хийхэд шаардагдах 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012	ЗБЭХЯ
2	Улаанбаатар-Зуунмод чиглэлийн хатуу хучилттай замыг шинэчлэн засварлах асуудлыг шийдвэрлэх	2012	ЗТБХБЯ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар  
хот

### Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн талаар авах арга хэмжээний тухай

Улсын нөөцийн тухай хуулийн 5.1.2, 6.1-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шатахууны хомсдолын улмаас үүсэж болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дулааны цахилгаан станцуудыг хангадгаас бусад нүүрсний уурхайд дизелийн түлш нийлүүлэх ажлыг 10 хоногийн хугацаагаар түр зогсоох зохицуулалтын арга хэмжээг газрын тосны бүтээгдэхүүн борлуулагч аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгасугай.

2. Улсын нөөцөөс 2050 тонн дизелийн түлш гаргахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод зөвшөөрч, уг дизелийн түлшийг одоогийн мөрдөгдөж байгаа жижиглэн худалдаалах үнээр газрын тосны бүтээгдэхүүн борлуулагч аж ахуйн нэгж, байгууллагад худалдаж, борлуулалтын орлогыг улсын нөөцийн бараа борлуулсан орлогын дансанд төвлөрүүлэн дизелийн түлшийг нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт тус тус даалгасугай.

3. Улаанбаатар хотын нийтийн тээвэрт хэрэглэх дизелийн түлшний хуваарилалт, хэрэглээнд хатуу хяналт тавин, түлш хэмнэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр, Зам, тээвэр, барилга,





хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

4. Улаанбаатар хот, Дархан-Уул, Говьсүмбэр аймагт нийт 60.0 мянган тоннын багтаамж бүхий автобензин, дизель түлшний улсын нөөцийн агуулах барихад шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиудын төсөлд тусган барих арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД**

**Д.ЗОРИГТ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмэгтэгийн редакци

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turin\\_medeelel@parliament.mn](mailto:turin_medeelel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэргэлийн үүдэс 2

Нийлэл: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.  
Үеэс 329487